



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын нийгмийн эмзэг бүлгийн
иргэдэд үзүүлэх сүрьеэгийн тусламж, үйлчилгээг
зохицуулах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг “Энэрэл” эмнэлэг шинэ байранд шилжин орсноор өрөө тасалгааны хүрэлцээгүй байдал үүссэнийг харгалзан тус эмнэлгээс орон гэргүй, тэнэмэл, оршин суух хаяггүй, бичиг баримтгүй иргэдэд үзүүлж байсан сүрьеэгийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг 2016 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн Халдварт өвчин судлалын үндэсний төв /Я.Буянжаргал/-д шилжүүлсүгэй.

2. Сүрьеэгийн хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ аваад, сорьц сөрөг болсон иргэдийг Энэрэл эмнэлэгт хүлээлгэн өгч, мэдээллээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Я.Буянжаргал/-д, сүрьеэгийн сорьц сөрөг иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг /сүрьеэгийн илрүүлэг, үзлэг, оношлогоо, эмчилгээ, сурталчилгаа/ амбулаторийн хэлбэрээр үргэлжлүүлэн үзүүлж тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/, Энэрэл эмнэлэг /Ш.Хүрэлчулуун/-т тус тус үүрэг болгосугай.

3. Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн дунд сүрьеэг илрүүлэх үзлэг шинжилгээг тогтмол зохион байгуулах, сүрьеэгээс урьдчилан сэргийлэх, эмийн гаж нөлөө, эмчилгээний явцад гарч болох хүндрэл, эмэнд дасалтай сүрьеэгийн хор уршгийн талаар сургалт, сурталчилгаа явуулах, энэ үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудын тусламж дэмжлэгийг авч хамтран ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газар /Ш.Энхбат/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Я.Буянжаргал/, Энэрэл эмнэлэг /Ш.Хүрэлчулуун/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080157